

БНХАУ-ЫН ӨМӨЗО-НЫ МУЗЕЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

О. Солонго

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль
songoo3891@gmail.com*

О. Болормаа

*Доктор (Ph. D.)
Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль
bolrmaa.o@must.edu.mn*

Хураангуй: Монгол улс хойд, өмнөд талаараа ОХУ, БНХАУ гэсэн их гүрнүүдтэй хиллэн оршиж түүх, соёлын байнгын харилцаанд орж байдаг. Тус өгүүлэлд БНХАУ-ын ӨМӨЗО-ны музей болон соёлын салбарын хөгжлийн чиг хандлагын талаар судалгаа хийхийг зорилоо. Судалгааг ӨМӨЗО-ны хот болон орон нутгийн музейдийг харьцуулан хийж, өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудалд дүгнэлт хийж, шийдвэрлэх боломж, арга замын талаар өөрийн саналыг тусгалаа.

Түлхүүр үгс: Соёлын биет өв, музей, соёл

I. УДИРТГАЛ

БНХАУ-ын эдийн засаг сүүлийн хориод жилийн хугацаанд эрчимтэй хөгжсөнөөр нийгмийн соёлын түвшинг дээшлүүлэх тал дээр илүү анхаарч эхэлсэн байдаг. Иймээс БНХАУ-ын Засгийн газраас Соёл, аялал жуулчлалын салбартаа их хэмжээний төсөв төвлөрүүлэх болсноор улсын болон хувийн статустай музейг бүх талаар нь дэмжих бодлого хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэхүү судалгаанд ӨМӨЗО-ны Хөх хот, Ордос аймгийн улсын болон хувийн зарим музейн жишээн дээр харьцуулсан судалгаа хийхийг зорилоо. Үүнд:

1. ӨМӨЗО-нд Музей хөгжиж ирсэн түүхэн тойм
2. ӨМӨЗО-ны музейн салбарын хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлс, үр дүнг судлах
3. ӨМӨЗО-нд хувийн музей байгуулах боломж, ашиг тусыг тодорхойлох зэрэг асуудлаар нарийвчлан судлахаар зорьсон болно.

II. ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

БНХАУ-ын Үндэсний Соёлын Өвийн Захиргаанаас (国家文物局) 2009 оны байдлаар улсын хэмжээнд нийт 2900 гэж тоологдож байсан музей 2019 оны статистикаар 5535 болж өссөн. Үүнээс 177 нь ӨМӨЗО-нд байдаг байна. “2019

оны ӨМӨЗО-ны музейн нөхцөл байдлын дэлгэрэнгүй мэдээллийн дүн шинжилгээний тайланд” 2018 оны байдлаар нийт 109 музей байсан гэж тоологдсон байдаг. Дээрх тоон мэдээнээс харахад сүүлийн 2 жилийн хугацаанд тус бүс нутгийн хэмжээнд музей 68 ширхэгээр буюу 38.4%-иар өссөн гэсэн нилээд өндөр үзүүлэлт харагдаж байна. Хувь хүн болон байгууллагын эрхлэн гаргасан хувийн музей ч энэ тоонд багтсан болно.

БНХАУ-д музейг ач холбогдол, үнэт байдлаар нь гурван зэрэглэлд ангилдаг. ӨМӨЗО-ны хувьд 1-р зэрэглэлийн 2, 2-р зэрэглэлийн 9, 3-р зэрэглэлийн 17 ширхэг музей байх ба үлдсэн 149 нь ямар нэг улсын зэрэглэлгүй музейд хувь хүн болон байгууллагын музейд байна. Эхний I, II зэрэглэлийн музейдийг дор хүснэгтээр үзүүлээ.

Хүснэгт 1. ӨМӨЗО-ны 1, 2-р зэрэглэлийн музейн жагсаалт

№	Музейн нэр	Төрөл	Зэрэглэл	Үнэгүй нээлт-тэй эсэх	Цуглуулгын тоо (хэсэг багц)	Соёлын үнэт дурсгалууд (ширхэг)
1	Өвөр Монголын музей	Соёлын дурсгал	I	Тийм	149,689.0 0	5,645.00
2	Ордос музей	Соёлын дурсгал	I	Тийм	19,120.00	930.00
3	Бугат хотын музей	Соёлын дурсгал	II	Тийм	130,365.0 0	219.00
4	ӨМӨЗО-ны ерөнхий газрын музей	Соёлын дурсгал	II	Тийм	115,047.0 0	96.00
5	Хөх Хотын музей (Гүнжийн харшийн тусгай музей)	Соёлын дурсгал	II	Тийм	22,663.00	170.00
6	Хөлөнбуйрын үндэсний музей	Соёлын дурсгал	II	Тийм	14,079.00	396.00
7	Тунляо музей	Соёлын дурсгал	II	Тийм	47,393.00	1,034.00
8	Чифэн хотын музей	Соёлын дурсгал	II	Тийм	88,223.00	1,390.00
9	Балин баруун хошууны музей	Соёлын дурсгал	II	Тийм	81,749.00	564.00
10	Ордос хүрэлийн музей	Соёлын дурсгал	II	Тийм	18,292.00	1,223.00
11	Алаша музей	Соёлын дурсгал	II	Тийм	32,518.00	92.00

国家文物局-Үндэсний соёлын өвийн захиргаа

Энэ тоо бол зөвхөн улсад бүртгэгдсэн албан ёсны музейн тоо бөгөөд албан ёсны бүртгэлгүй музей ч цөөнгүй байдаг. ӨМӨЗО-ны музейн хөгжил, өнөөгийн байдлын талаар ярихын өмнө БНХАУ-ын улсын музейн хөгжлийн талаар дурдахгүй өнгөрөх аргагүй. БНХАУ-ын музейн түүх 1905 оноос

бичигдэж эхэлжээ. МЭӨ 478 онд Шаньдун мужийн Кузао хотод Күнзийн хуучин оршин сууж байсан газарт байгуулагдсан сүмд Күнзийн амьд ахуйдаа хэрэглэж байсан хувцас, толгойн өмсгөл, төгөлдөр хуур, тээврийн хэрэгсэл зэргийг олон нийтэд дэлгэн тавьжээ. Энэхүү Күнзийн сүмийг БНХАУ-ын хамгийн эртний дурсгалын музей байсан гэж хэлж болно. Орчин үеийн БНХАУ-ын музейн түүх нь 1848 оноос эхлэх ба гадаадын аялагч жуулчид олон төрлийн сонин содон зүйлсийг олон нийтэд дэлгэн үзүүлэх болсноор музейг тус улсад шинэ зүйл болгон нэвтрүүлж эхэлсэн байдаг. 1905 онд Жан Сай (张赛 их сурган хүмүүжүүлэгч, эх оронч, зохион бүтээгч) хувийн хөрөнгөөрөө Жиан Су (江苏) мужийн Нан Тонг (南通) хотод анхны орчин үеийн музейг байгуулсанаар БНХАУ-д музей эрчимтэй хөгжиж эхлэсэн.

Зураг 1. НанТонг-ны музей (南通博物院)



Улсын хэмжээнд анх байгуулагдсан олон нийтийн музей бол 1914 онд нийслэл Бээжин хотод нээгдсэн эртний эдлэлийн үзэсгэлэн байв. 1949 онд Коммунист намын дарга Мао Зэдун (毛泽东) БНХАУ байгуулагдсаныг зарлан тунхаглаж 1956 он гэхэд социалист өмчлөлийн тогтолцоог бүрэн халахаар ажиллаж байхдаа 1958 онд нийгмийн бүхий л салбарт «Их үсрэлтийн бодлого» явуулж, энэ бодлогын хүрээнд "Үндэсний ажил хэрэг" хөдөлгөөн өрнөн дээд цэгтээ хүрсэн нь музейн салбарыг ч тойрсонгүй. Хятадын өнцөг булан бүрт хувьсгалт дурсгалыг өнгөрсөнтэй харьцуульсан үзмэрүүд гарч байсан нь орчин үеийн соёлын дурсгалт зүйлийг цуглуулах, ангилах, сурталчлах ажлыг бэхжүүлсэн юм. 1957 онд ӨМӨЗО-ны 10 жилийн ойгоор өөртөө засах орны хэмжээнд анхны музей нийслэл Хөх Хотод “Өвөр Монголын Музей” нэртэйгээр байгуулагдаж байсан.

Зураг 2. Анхны “Өвөр Монголын Музей” (内蒙古博物馆) 1957 он



Зураг 3. Хөх Хотын музей (呼和浩特博物馆) 2017 он



Харин 2007 онд тус музейг 10 дахин томруулсан орчин үеийн музейн чанар, стандартыг хангасан шинэ музей байгуулж “Өвөр Монголын музей” нэрийг шилжүүлэн өгч хуучин музейг “Хөх Хотын Музей” болгон өөрчилсөн.

Зураг 4;5. Өвөр Монголын Музей (内蒙古博物馆) 2019



Зураг 6. Ордос Хүрлийн Музей (鄂尔多斯青铜器博物馆) 2020



“Ордос Хүрлийн музей”-г түшиглэн холгүйхэн байгуулагдсан цэцэрлэгт хүрээлэнд музейн үзмэрүүдийг дууриалгаж хийсэн овор ихтэй баримлуудыг байрлуулж тавьсан нь музей гэдэг заавал нэг барилга дотор шилэн хоргонд байрлуулсан үзмэрийн цуглуулга биш байгаль дэлхий ч гэсэн өөрөө музей гэсэн санааг илтгэх мэт.

Зураг 7. Ордос хүрлийн үеийн соёлын талбай (鄂尔多斯青铜文化广场)2020



Зураг 8. Музейн үзмэрийг дууриалгаж хийсэн баримал



Зураг 9. “Нутаг” амьтан ургамлын ардын музей (努图克动植物民间博物馆) 2019



Зураг 10. “Нутаг” амьтан ургамлын ардын музей (努图克动植物民间博物馆) 2019



III. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

"Их үсрэлт" бодлогын хүрээнд 1959 онд ӨМӨЗО-нд бусад олон муж, хотуудын нэгэн адилаар хувьсгалт дурсгалын танхимуудыг байгуулжээ. 1960 оны 1-р сард Шанхай (上海) хотноо болсон Намын Төв Хорооны Улс төрийн товчооны хурлаар "Их үсрэлт" уриаг дэмжин цаашдын хөгжлийн бодлогоо боловсруулсан нь музейн үйл ажиллагаа, бизенесийн хөгжлийн хөтөлбөрүүдийг багтаасан байсан ба хурлаас гарсан бодлого баримтлалыг хэрэгжүүлэхээр сонгосон муж, хотуудын тоонд ӨМӨЗО багтсан байсан. Түүнчлэн Мао Зедун музейг хөгжүүлэхдээ тухайн газар орны онцлог, соёл уламжлалыг хадгалан, харуулсан байхыг давхар даалгасан нь Өвөр Монголын музейн өнөөгийн хөгжлийн үндсэн суурь болж чадсан.

2007 оноос ӨМӨЗО-ны соёлын аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх тал дээр эрчимтэй ажиллаж эхлэсэн. Тус оны 7-р сард БНХАУ-ын статистикийн үндэсний хорооноос хөгжлийн суурь төлөвлөгөөг гаргасан байдаг. Тухайн судалгаанд ӨМӨЗО хоцронгуй хөгжилтэй байгаа нь соёлын аж үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд харин ч ашигтай гэж үзээд, тулгарч байгаа хүндрэл бэрхшээл, тэдгээрийн шалтгааныг нэг бүрчлэн авч үзсэн байдаг. Үүнд:

1. Салбарын цар хүрээ хэтэрхий бага
2. Хөгжлийн тэнцвэргүй бүс нутаг
3. Үндэслэлгүй аж үйлдвэрийн бүтэц

4. Соёлын бүтээгдэхүүний технологийн агуулга, нэмүү өртөг өндөр биш
5. Соёлын бизнесийн зах зээлийн амьдрах чадвар хангалтгүй
6. Дэд бүтцийг бэхжүүлэх шаардлагатай хэвээр байна гэжээ. [1]

Ийнхүү БНХАУ нь Улс, соёл, аж үйлдвэрийн үндэсний эдийн засаг, шинэчлэлийн ерөнхий төлөвлөгөөндөө ӨМӨЗО-ыг эдийн засгаараа хоцрогдсон бүс нутгийн хувьд соёлын аж үйлдвэрийг хөгжүүлэхэд ихээхэн боломжтой гэж үзээд үндэсний соёлын бүс нутгийг бий болгох гэсэн стратегийн үзэл баримтлалыг дэвшүүлжээ.

ӨМӨЗО нь соёлын баялаг өв, нөөцтэй бөгөөд сүүлийн жилүүдэд үндэсний болон бүс нутгийн онцлог шинж чанартай соёлын дурсгалт зүйлс, уран зохиол, урлаг, хэвлэн нийтлэх, өргөн нэвтрүүлэг, кино, телевиз болон бусад соёлын талбарт улам бүр өргөжин хөгжиж байгаа.

ӨМӨЗО нь хүн төрөлхтний соёл иргэншлийн өлгий нутаг бөгөөд бэлчээрийн соёлын эх сурвалж юм. Хүннү, Сяньби, Кидан, Монгол болон бусад ард түмний газар дээрхи болон доорхи соёлын дурсгалууд нь нийт нутаг даяар нь тархсан байдаг. Тус бүс нутгаас олдсон соёлын дурсгалт зүйлүүд улсын бусад хэсэгт байдаггүй ба нийт 15000 соёлын дурсгалт зүйл олдсоноос 35 соёлын гол дурсгал улсын хамгаалалтад, 158 соёлын дурсгал нь өөртөө засах орны хэмжээнд хамгаалалтад байдаг. Нийт ӨМӨЗО-ны цуглуулгад 500000 гаруй багц соёлын дурсгал байдаг бөгөөд зарим соёлын дурсгалт зүйлийг АНУ, Хонг Конг, Тайвань, Монгол гэх мэт улс орнуудад дэлгэн үзүүлсэн байдаг. Жишээ нь: Үлэг гүрвэлийн үзэсгэлэн, Ляо гүрний соёлын дурсгалт зүйлсийн үзэсгэлэнг АНУ-д, "Хятан-Их Ляо улс үзэсгэлэнг Монголд гэх мэт. [1]

2019 он бол БНХАУ улс байгуулагдсаны 70 жилийн ой тохиожээ. Тухайн жилд БНХАУ-ын Засгийн газраас олон ажлыг төлөвлөж хийсний дотор БНХАУ-ын Соёл, Аялал Жуулчлалын Яамны Соёл, Аялал Жуулчлалыг хөгжүүлэх тухай стаистик төлөвлөгөө байсан юм. (中华人民共和国文化和旅游部 2019 年文化和旅游发展统计公报). Энэ төлөвгөөг гаргахдаа өмнөх онуудын тоон мэдээлэл дээр тулгуурлан тухайн жилийн төлөвлөгөө, дүгнэлт гаргасан ба дэлгэрүүлэн харахад улсын хэмжээнд соёл, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд нэлээдгүй анхаарч их хэмжээний хөрөнгө оруулалт хийж буйг харж болох юм. Тухайлбал, 2019 оны сүүлийн байдлаар Соёлын өвийг хамгаалах, ашиглах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 10562 байгууллага байгаагийн 3518 буюу 33.3% нь соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бол 48.6% буюу 5132 байгууллага ямар нэгэн байдлаар музейн үйл ажиллагаа эрхэлдэг байна. Жилийн эцэст улсын хэмжээнд соёлын дурсгалт газруудад 162400 ажилтан

ажиллаж байсан нь өмнөх оны эцсээс 0.02%-иар нэмэгджээ. Үүнээс 10123 (6.2%) ахлах цолтой, 21176 (13.0%) дунд цолтой боловсон хүчнүүд байна. Мөн үндэсний соёлын дурсгалт зүйлсэд зарцуулах зардал 41.54 тэрбум юань болж, өмнөх оныхоос 3.661 тэрбум юань буюу 9.7% -иар өссөн нь улсын төсвийн нийт зардлын 0.18% -ийг эзэлж, өмнөх оноос 0.01%-иар өссөн байна. Нийт хүн амын соёл, аялал жуулчлалын зардал 106.502 тэрбум юань болж, өмнөх оныхоос 13.67 тэрбум юань буюу, 14.7%-иар өсч, нэг хүнд ногдох соёл, аялал жуулчлалын зардал 76.07 юань болж, өмнөх оноос 9.54 юань буюу 14.3% -иар өссөн байна. [2]

Харин ӨМӨЗО-ны хувьд 2018 оны байдлаар хүн амын соёл урлаг, үзвэр үйлчилгээний нэг хүнд ногдох хэрэглээний зардал 738 юань болж, 2013 оныхоос 16.8% -иар өсч, жилийн дундаж өсөлт 3.2% -тай байна. Үүний дотор хот суурин газрын иргэдийн нэг хүнд ногдох соёл, зугаа цэнгэлийн хэрэглээний зардал 1'066 юань болж, 2013 оныхоос 8.8% -иар өссөн байна. [3]

Дээрх тоон мэдээнүүдээс харахад хүчирхэг эдийн засагтай орны хувьд БНХАУ нь нийгмийг хөгжүүлэхэд чиглэсэн салбарууд болох соёл, боловсрол, спорт, эрүүл мэндийн салбаруудаа ихээхэн дэмжиж, хөрөнгө мөнгө зарцуулж байгаа нь шууд харагдаж байна.

Өнөөгийн БНХАУ-ын засгийн газрын соёл, аялал жуулчлалын бодлого хэрэгжүүлэх салбарын бүх шатны удирдлагууд дунд соёл, урлагын мэргэжлийн боловсролтой боловсон хүчний хомс байдал ажиглагддаг.

Сүүлийн жилүүдэд шинээр олон тооны музей байгуулагдаж байгаа нь олон нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх олон талын ач холбогдолтой ч ихэнх музейн үзүүлэгийн танхимын дийлэнх үзмэр нь дууриалган хийсэн хуурамч зүйлс, нүсэр ханын зураг байх нь олширсон гэж үздэг. Музейн барилга байгууламжийн хувьд өндөр түвшинд хийгддэг байна. Мэргэжлийн аль нэг байгууллагад хандаад чанар стандартыг бүрэн хангасан барилгыг богино хугацаанд барих явдал нээлттэй аж. Нэгэнт боссон барилгыг жинхэнэ музей болгож үзмэрүүдийг цуглуулах, дэглэх нь эрдэмтэн судлаач, мэргэжилтэн гэсэн өндөр түвшний мэргэшсэн боловсон хүчнээс бүрэлдсэн багийн багагүй хугацаанд гүйцэтгэх ажил байдаг тул анхааран ажиллаж байна.

IV. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Дээрх тулгамждаж буй асуудлаар хийгдсэн судалгааны үр дүнгээс харахад өнөөгийн ӨМӨЗО-ны музейн салбарт доорх асуудлууд тулгараад байна.

1. Төрөөс цөөн тоот үндэстнүүдийн өв соёлыг хамгаалах тал дээр хэтэрхий ерөнхий агуулгатай бодлого баримталдаг.

2. Бодлого хэрэгжүүлэгч улсын ажилтнуудын соёл урлагийн боловсрол хангалтгүй.

3. Гүйцэтгэх шатны албан тушаалтнууд Соёлын аж үйлдвэрлэлийг хэтэрхий бизнес тал руу хандуулсан.

4. Чанар биш харагдах байдал, тооны хойноос хөөцөлдсөн.

5. Төсөл хэрэгжүүлэгч мэргэжлийн багийн бүрдүүлэлт дутагдалтай.

6. Ажлын байрны мэргэжлийн боловсон хүчний тутмаг байдал зэрэг болно.

Жишээ нь, Ордос аймгийн төв Дунг Шэнг хотод байдаг “Ордос Хүрлийн музей” -н хувьд тухайн бүс нутгаас олдсон, дэлхийд танигдаж алдаршсан зөвхөн хүрлийн үеийн олдворын үнэт цуглуулгатай. Дан ганц дотоодын үзэгчид гэхгүй дэлхийн өнцөг булан бүрээс судлаачид, сонирхогчид зорьж очдог газар болсон.

Сүүлийн жилүүдэд хувийн цуглуулагчдын тоо нэмэгдэж байгаа нь энэ нөхцөл байдалтай холбоотой байх үндэслэлтэй. Эдгээр цуглуулагчдыг дэмжиж, тэдний цуглуулгын хандиваар хувийн музейнүүдийг байгуулах нь ӨМӨЗО-ны Монгол үндэстнүүдийн өв соёл, уламжлалт ахуйгаа бүрэн сэргээхгүй юм аа гэхэд мартахгүй байх боломжийг олгох нэг гарц болох боломжтой.

БНХАУ-ын эрдэмтэн судлаач Ли Сяюань (李晓媛) 2016 онд хийсэн “ӨМӨЗО-ны хувийн музейн өнөөгийн байдал, хөгжилийн сөрөг арга хэмжээ” нэртэй судалгааны ажилдаа “Түүх, соёлын өвийн арвин их нөөцтэй ӨМӨЗО-нд улсаас хувийн музей хөгжүүлэхийг дэмжиж байгаа. Түүнчлэн хувийн музейн тоогоороо манай улсад тэргүүлдэг. Гэвч эсрэгээрээ тус бүс нутгийн хувийн музейн хөгжлийн түвшин, стандартчиллын зэрэг хангалтгүй байдаг” гэж тодорхойсон. [4]

Үүнийг батлан өнөөгийн ӨМӨЗО-ны хот, хөдөө орон нутгийн хэмжээнд төрийн дэмжлэгтэйгээр байгуулалгдаж, үйл ажиллагаа эхлэсэн ч байнгын идэвхтэй үйл ажиллагаагүй, үзэгчгүй, зорьж очсон цөөн тооны үзэгчид цоожтой хаалга мөргөх өндөр магадлалтай нилээд олон тооны музей байдаг болсон. БНХАУ-ын урлагийн мэдээ (中国艺术报) судлаачдын онлайн флатформ дээр байрлуулсан археологч эрдэмтэн доктор Жоу Сяолу-ны (周晓陆) ярилцлаганд “Хувийн музейн зохион байгуулалт, менежментийн тал дээр мэргэжлийн ур чадварын хомсдолын асуудал онцгой анхаарал татаж байна. Хувийн музейн хувьд чадварлаг зохион байгуулагч, мэргэжлийн боловсон хүчнийг хэрхэн бэлтгэж, авч үлдэх нь хамгийн чухал бөгөөд байнгын ажиллагаатай, амжилттай музей байх гол ноён нуруу бол мэргэжлийн боловсон хүчин байдаг” гэжээ.

Иймд соёлын өвийн баялаг нөөцтэй гэж тодорхойлогдсон ӨМӨЗО-нд олноороо байгаа хувиараа цуглуулагчдын хандив дээр суурилан мэргэжлийн багийг бүрдүүлэн, маркетинг менежментийн зөв бодлогыг хэрэгжүүлж чадвал хувийн музейг улсын дэмжлэгтэйгээр байгуулах бүрэн боломж байгаа нь харагдаж байна.

Ү. ДҮГНЭЛТ

ӨМӨЗО-ны Монгол үндэстнүүдийн хувьд хойч үе нь өв соёл, ахуй уламжлалаа мартаж гээх нь цаг хугацааны асуудал болсон ба тэдний өмнө тулгарч байгаа гол бэрхшээлтэй асуудлуудын нэг хэмээн үзэж болно. Энэ тулгамдаж байгаа асуудлыг удаашруулж чадах нэг хүчин зүйл бол орон нутгийн музейн салбарын хөгжил бөгөөд Өвөр монголчууд өдөр тутмын ахуй амьдралдаа өв соёл, ахуй уламжлалаа мартаж орхигдуулалгүй хадгалж, хамгаалж үлдэхэд нь туслах асар их үүрэгтэй юм. Иймээс Өвөр Монголын орон нутгийн музейн чиг хандлагыг судлах явцад музейн салбар цаашдын хөгжилдөө дараах үйл ажиллагааг баримтлан ажиллахаар зорьж байгааг нээн илрүүлээ. Үүнд:

1. Бусад үндэстний нөлөөнөөс үүдэж тоо нь тасралтгүй өсөн нэмэгдэж байгаа мартагдах шахсан соёлын өвөө бүртгэж, баримтжуулах, олонд сануулах, таниулах үйл ажиллагааг байнга зохион байгуулах.

2. Соёлын өвийн (биет болон биет бус) эх сурвалжийг цаг алдалгүй хайн илрүүлж, түүнд зориулсан төсөл төлөвлөгөө боловсруулж, улсаас дэмжлэг авч, бодит үр дүнг (хувийн музей, ардын авъяастнуудыг баримтжуулсан баримтат кино, клип гэх мэт) бий болгож нийтэд түгээх.

3. Нэгэнт сонгогдсон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ мэргэжлийн чадварлаг боловсон хүчнийг урьж оролцуулах.

4. Мэргэжлийн боловсон хүчнүүдийг тасралтгүй нэмэгдүүлж, системтэйгээр дотоод, гадаадын сургалтуудад хамруулж мэдлэг, ур чадварыг нь байнга дээшлүүлэх.

5. Техник технологийн үсрэнгүй хөгжлийг ашиглан, 21-р зууны үндсэн тодорхойлолт болсон мэдээллийн хүчийг ашиглан хөгжих зэрэг үндсэн асуудлууд багтжээ.

НОМЗҮЙ

1. *Монголын Үндэсний Музей., Музей Судлал. Улаанбаатар: <<Мөнхийн Үсэг>>, 2017, 147 х.*
2. http://www.stats.gov.cn/zjtj/ztfx/dfxx/200707/t20070711_33483.html
3. https://www.mct.gov.cn/whzx/ggtz/202006/t20200620_872735.htm
4. <http://tj.nmg.gov.cn/zlqsnfjxsd/11898.html>